



**ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН  
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН  
ТУШААЛ**

2022 оны 03 сарын 02 өдөр

Дугаар A/15


Улаанбаатар хот

**Ажиллагсдын дархлааг дэмжих тухай**

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2, 20.2.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ажиллагсдын дархлааг дэмжих аяны удирдамжийг 1 дүгээр, аянд шаардагдах төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай зардлыг холбогдох зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Х.Одгэрэл/-д зөвшөөрсүгэй.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, маркетингийн албаны дарга /Ч.Батболд/-д үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Н.ЭРДЭНЭБАЯР

080083

**“ДАРХЛААГАА ДЭМЖИЦГЭЭ” АЯНЫ УДИРДАМЖ**

**Нэг. Зорилго:**

Эрүүл мэндийн ажилтнуудын дархлааг дэмжих талаарх ЦССҮТ-ийн Хөдөлмөрийн дотоод журам, Хөдөлмөрийн хамтын гэрээний хэрэгжилтийг хангах, Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн ажиллагсдыг Корона вируст халдвар /КОВИД-19/-аас урьдчилан сэргийлэх, эмийн бус аргаар дархлааг нь дэмжихэд оршино.

**Хоёр. Зорилт:**

- Ажиллагсадын дархлааг дэмжих;
- Корона вируст халдвар /КОВИД-19/ болон Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээрх ажиллагсдын мэдлэг хандлагыг нэмэгдүүлэх;

**Гурав. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

1. Дархлаа дэмжих цэгэн иллэгийг ажилтан бүр өдөрт 2-3 удаа хийж хэвших;
2. Халуун аарц нийт ажиллагсдад өдөрт 1 удаа олгох;
3. Томуу, томуу төст өвчнөөс сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулах

**Дөрөв. Хугацаа**

Тус аян нь 2022 оны 3 дугаар сарын 02-ны өдрөөс 2022 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн хооронд 2 сарын хугацаатай үргэлжилнэ.

**Тав. Хамрах хүрээ**

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн нийт ажиллагсад

**Зургаа.Хариуцах эзэн**

Санхүү, бүртгэлийн алба, Цусны чанар, аюулгүй байдлын алба


**Долоо. Хамтран ажиллах**

Төвийн бүх алба, тасгууд

**Найм. Хүрэх үр дүн**

Корона вируст халдвар /КОВИД-19/ болон Томуу, томуу төст өвчнөөс хэрхэн сэргийлэх чиглэлээр ажиллагсадын мэдлэг хандлага нэмэгдэн, дархлааг дэмжсэнээр өвчлөлөөс урьдчилан сэргийлж, ажлын бүтээмж нэмэгдэнэ.

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын 2022 оны  
03. сарын 02 өдрийн 4/5 дугаар тушаалын  
2 дугаар хавсралт



**“ДАРХЛААГАА ДЭМЖИЦГЭЭ” АЯНД ЗАРЦУУЛАГДАХ  
ДАРХЛААЖУУЛАЛТЫН ТӨСӨВ**

№	Шаардагдах зүйлс	Савлагаа	Тоо, ширхэг	Нэгж үнэ /төг/	Нийт үнэ Төг
1	Аарц	500 гр	440	5.000	2,000,000
2	Сургалтын зардал		1	200,000	200,000
	Нийт				2,200,000